



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №03

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2023 оны 1-р сарын 04-26 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2023 оны 1-р сарын 04-26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H3N8, H7N9, H6N1, H10N8, H7N4, H5N8, H10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

2023 оны 01-р сарын 07 нд шувууны томуугийн А хүрээний H5 вирусийн хүний өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн. Эквадор улсын Боливар мужид 9 настай эмэгтэй хүүхдэд 1-р сарын 02 нд шинж тэмдэг илэрч нас барсан. Хүүхэд тахиа тэжээдэг өгүүлэмжтэй. Мөн H5N6 вирусийн хэв шинжээр БНХАУ-ын Хунань мужийн төв Чанша хотод 54 настай эрэгтэй өвдсөн 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2023 оны 1-р сарын 04-26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус 17 улс орны газар нутагт тэжээвэр болон нүүдлийн шувууд, хөхтөн амьтад өвчилсөн тохиолдолоуд бүртгэгдсэн.

Тэжээвэр шувуудын өвчлөл: А хүрээний H5N1 хэвшинжийн вирусээр АНУ-ын 8 мужийн газар нутагт 12 шувууны аж ахуйд /цацагт хяруул, гургуул, тахианы аж ахуй/, Молдав улсын Курестина тосгонд тахиа шувууны аж ахуй, Болгар улсын Етрополе хотод бөднө шувууны аж ахуй, Чех улсын Добриниш мужийн нугасны аж ахуй, Япон улсын газар нутаг Маэбаси хот, Канад улсын Порт-Алберни хот, ОХУ-ын Калининград хот, Австри улсын Вельс-Ланд дүүрэг, Унгар улсын Будапешт хотуудын тахиа шувууны аж ахуйн тус бүр 1 тохиолдол, ХБНГУ-ын зүүн хойд хэсэг болох Мекленбург-Өрнө Померан, Тайвань улсын Юньлинь мужид 2 шувууны аж ахуй, Франц улсын 3 мужид 11 шувууны аж ахуй тус тус бүртгэгдсэн.

Нүүдлийн шувууд: А хүрээний H5N1 хэвшинжийн вирусээр АНУ-ын 30 мужийн газар нутагт 127 нүүдлийн болон суурин шувууд (нугас, бүргэд, хэрээ, галуу, тас, тогоруу,

шунгуур, шумбуур, хотон, цахлай, шар шувуу зэрэг 10 төрлийн 16-18 зүйлийн шувууд), Япон улсын газар нутагт 27 зүйлийн 280 шувуу (2022 оны 12 сараас), КостаРика улсын Лимон мужид хотон (3), ОХУ-ын Ставропольский Край мужид хэрээ (2), тоть шувуу (6), Швед улсын Треллеборг хотод сар (1) болон бор галуу (1), Чили улсын Пичилему хотод хотон (1), Бүгд Найрамдах Хондурас Улсад Ла-Сейба хотод хотон (41), Словени улсын Обално-Крашка мужид гунгар хун (2) тус тус бүртгэгдсэн.

Хөхтөн амьтад: А хүрээний H5N1 хэвшинжийн вирусээр Шотланд улсад голын халиу (4), Англи улсад үнэг (4), Испани улсад булга *Neovison vison* (1), АНУ-д баавгай (3) /2022 оны намраас хойш/, *Procyon lotor* (2), ОХУ-н Дакистаны Каспийн тэнгисийн эрэгт 700 орчим далайн хав /2022 оны 12 сараас/ Дани улсад үнэг (3) тус тус бүртгэгдсэн.

ЗӨСҮТ-Шувууны томуу хариуцсан баг